

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ МЭРГЭЖЛИЙН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийгмийн даатгалын эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитийн мэргэжлийн хороо /цаашид “Хороо” гэх/-ны үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Хороо нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах зорилготой ажиллана.

1.3 Хороо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид Үндэсний зөвлөл” гэх/-ийн дэргэд ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, нийгмийн даатгалын аливаа асуудлаар шийдвэр гаргахад мэргэжлийн зөвлөгөө, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.4 Журмын зорилго нь мэргэжлийн хорооны бүтэц бүрэлдэхүүн, хорооны гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.5 Хороо нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомж, Үндэсний зөвлөлөөс баталсан дүрэм, журам, шийдвэрийг мөрдөн ажиллана.

Хоёр. Хорооны бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн тооны хязгаар, үйл ажиллагааны чиглэл

2.1. Хороо нь нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах асуудлуудыг хариуцсан гишүүдтэй байна:

- 2.1.1. Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан 3 гишүүн;
- 2.1.2. Актуар тооцоолол хийх 2 гишүүн;
- 2.1.3. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан 2 гишүүн;
- 2.1.4. Аудитын асуудал хариуцсан 2 гишүүн.

2.2. Хорооны гишүүдийн үйл ажиллагааны чиглэл:

- 2.2.1. Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан гишүүн;

2.2.1.1. нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтад хяналт тавих, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл болон эрсдэлийн сангийн хөрөнгийг банкинд байршуулах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад судалгаа тооцоолол хийх, эрсдэлийг үнэлэх, дүгнэлт, санал боловсруулах

2.2.2. Актуар тооцоолол хийх гишүүн;

2.2.2.1 Хүн амын насны бүтэц, интервалаар тооцсон тооцоолол, төрөлтийн хувь хэмжээний өөрчлөлт, үнийн өсөлт зэрэг нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн хүчин зүйлүүдийн нөлөөллийг харгалзан нийгмийн даатгалын хэтийн орлого зарлага, иргэдийн төлөх даатгалын шимтгэл, тэтгэвэр олголтын хэмжээ зэрэг тэтгэврийн тогтолцоонд зайлшгүй шаардлагатай хэтийн тооцоолол хийх.

2.2.2.2. нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн төлөв байдал, даатгуулагч, тэтгэвэр авагчдын тоо хэмжээ ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг тооцож, нийгэм эдийн засаг, холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан сангийн хэтийн төлөвийг тооцож, нийгмийн даатгалын шийдвэрт тусгуулах, санал боловсруулах.

2.2.3. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан гишүүн;

2.2.3.1. нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад судалгаа тооцоолол хийж, дүгнэлт, санал боловсруулах

2.2.4. Аудитын асуудал хариуцсан гишүүн;

2.2.4.1. нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаанд нийгмийн даатгалын хууль тогтоомж, Үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах

2.3. Хорооны гишүүд орон тооны бус байна.

Гурав. Хорооны гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх

3.1. Хорооны гишүүнийг Үндэсний зөвлөл нээлттэй сонгон шалгаруулж, томилж, чөлөөлнө.

3.2. Хорооны гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагааг Үндэсний зөвлөлийн ажлын алба /цаашид “ажлын алба” гэх/ хариуцна.

3.3. Ажлын алба сонгон шалгаруулалтын тов, үргэлжлэх хугацааг тогтоож, зарыг 14-өөс доошгүй хоногийн өмнө хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудас болон 5-аас доошгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй байдлаар олон нийтэд мэдээлнэ.

3.4. Хорооны гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1. Монгол улсын иргэн байх;

3.4.2. Хууль эрх зүй, эдийн засаг, санхүү банкны чиглэлээр магистрас

дээш боловсрол эзэмшсэн;

3.4.3. Мэргэшсэн чиглэлээрээ нийгмийн даатгал, статистик, аудит зэрэг байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

3.4.4. Мэргэжлийн ёс зүй, ашиг сонирхол, нэр хүндийн хувьд мэргэжлийн хорооны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

3.4.5. хугацаа хэтэрсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх /бүх төрлийн тэтгэвэр авагч хамаарахгүй/;

3.4.6. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;

3.5. Энэ журмын 3.4-т заасан шаардлагыг хангаж сонгон шалгаруулалтад оролцох иргэн дараах нийтлэг баримт бичгийг бүрдүүлж, цаасаар болон цахимаар ажлын албанд ирүүлнэ. Үүнд:

3.5.1. Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);

3.5.2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);

3.5.3. Хорооны гишүүнээр ажиллах зорилго, хүсэл эрмэлзлэл, хийх ажил, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн хүсэлт;

3.5.4. Иргэний үнэмлэхийн хуулбар;

3.5.5. цээж зураг 4х3-ийн хэмжээтэй 2 хувь.;

3.6. Ажлын алба сонгон шалгаруулалтанд оролцогсдын ирүүлсэн материалын бүрдлийг хянаж, шаардлага хангасан оролцогчдын жагсаалтыг гаргаж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулна..

3.7. Үндэсний зөвлөл нэр дэвшигчийн сонсгол хийж, оролцогсдоос нийгмийн даатгалын тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиглэлээр ажиллах хүсэл сонирхол, чадвар, туршлага, чадварыг шалгуур болгож, энэ журмын 2.1-д заасан үйл ажиллагааны чиглэл, тооны хязгаарт багтааж, нийт 9 хүнийг сонгож, мэргэжлийн хорооны гишүүнээр томилно.

3.8. Хорооны гишүүнийг 3 жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

3.9. Хороо анхдугаар хуралдаанаараа гишүүдийн олонхийн саналаар даргыг сонгоно.

3.10. Хорооны гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:

3.10.1. Бүрэн эрхийн хугацаа дууссан;

3.10.2. Нас барсан;

3.10.3.Нэр дэвшсэн байгууллагаа төлөөлөхгүй болсон;

3.10.4.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол гарсан;

3.10.5.Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

3.10.6..Ашиг сонирхлын зөрчил үүссэн.

Дөрөв. Мэргэжлийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагаа

4.1.Хороо нь энэ журамд заасан үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөг тухайн жилийн 1 дүгээр сарын 20-ний дотор Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна. Төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгасан байна:

4.1.1.Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа мэдээллээр байнга хангах.

4.1.2.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн батлах асуудлуудад гишүүдийг бүхий нотолгоонд суурилсан судалгааны баримт, мэдээлэл, лавлагаагаар мэргэжлийн үндэслэл шуурхай хангах:

4.1.2.1.Ажлын алба хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг хүлээн авч хянаад шаардлага хангасан баримт бичгүүдийг мэргэжлийн хороонд шилжүүлнэ.

4.1.2.2.Мэргэжлийн хорооны гишүүд хуралдаанаар хэлэлцэх асуудлууд баримт бичгүүдэд өөрсдийн хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр судалгаа тооцоолол хийж, эрсдэлийг үнэлэн, дүгнэлт, саналаа боловсруулан хорооны хуралдаанаараа хэлэлцээд 2 хоногийн дотор асуудал тус бүрээр зөвлөмжөө гаргаж, ажлын албанд хүргүүлнэ.

4.1.3.Нийгмийн даатгалын талаар хараат бус судалгаа хийх, санал зөвлөмж боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх.

4.1.4.Үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын албаны алба хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтыг тэдний санал хүсэлтэд үндэслэн дараах хугацаанд зохион байгуулах:

4.4.1.үндэсний зөвлөлийн гишүүдэд жилд 2 удаа

4.4.2.ажлын албанд улиралд 1 удаа.

4.2.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан 2 гишүүн Мэргэжлийн хороог төлөөлөн нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий олон нийтийн хяналтын зөвлөлд ажиллах.

4.3.Мэргэжлийн хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах ба гишүүдийн олонхи оролцсоноор хүчинтэйд тооцогдоно. Хэрэв Үндэсний зөвлөл ээлжит бус хуралдаан зарлавал тус хуралдаанаар хэлэлцэх асуудлуудад мэргэжлийн зөвлөмж өгөх чиглэлээр мэргэжлийн хороо мөн ээлжит бусаар хуралдана.

4.4.Хорооны хуралдаанаас зөвлөмж гарах бөгөөд хорооны дарга, хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурна.

4.5.Хороо зөвлөмж гаргах ажилд шаардлагатай мэдээллээ ажлын алба, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргуулан авч байгаа бол хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн жагсаалт үйлдэнэ.

4.6.Хорооны гишүүд ажлын алба, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргуулан авсан мэдээллийг зөвхөн албаны хэрэгцээнд ашиглах бөгөөд түүнийг хуулбарлах, гадагш авч гарах, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр тараахыг хориглоно.

4.7.Ажлын алба, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архивт хадгалагдаж байгаа мэдээлэлтэй танилцахдаа тэдгээр байгууллагын архивын үйл ажиллагааны журмыг мөрдөнө.

4.8.Мэргэжлийн хороо ажлаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд жил бүр тайлагнана.

4.9.Мэргэжлийн хороо нь үйл ажиллагааныхаа жилийн тайлан болон энэ журамд заасан мэдээлэл, зөвлөмж, дүгнэлтийг тухай бүрд нь ажлын албанд мэдээлнэ.

4.10.Мэргэжлийн хороод нь чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг журмын дагуу тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулна.

Тав. Мэргэжлийн хорооны дарга, гишүүний эрх, үүрэг

5.1. Мэргэжлийн хорооны дарга, гишүүн нь дараах эрхтэй байна. Үүнд:

5.1.1. Хуралдааныг зохион байгуулан хийж, даргалах

5.1.2.Нийгмийн даатгалтай холбоотой мэдээ, тайлан судалгааг холбогдох байгууллагаас гаргуулах авах.

5.1.3.Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцох.

5.1.4.Үндэсний зөвлөлийн даргын зөвшөөрлөөр хуралдааны материалтай танилцах, мэдээлэл авах.

5.1.5. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2. Хорооны гишүүн нь дор дурдсан үүрэгтэй байна. Үүнд:

5.2.1. Үндэсний зөвлөлийн гишүүдэд мэргэжлийн чиглэлээр сургалт хийх, мэдээлэл өгөх.

5.2.4.Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд бусад талуудыг мэргэжлийн

зөвлөгөө, мэдээллээр тэгш хангах.

5.2.3. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд болон ажлын албанаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.

5.2.2. Хууль дээдлэх зарчмыг мөрдлөг болгон мэргэжлийн ёс зүйг чанд баримталж аливаа ашиг сонирхлын зөрчил, хууль бус үйлдлээс ангид байх.

5.2.6. Хууль, тогтоомжид заасан бусад үүрэг.

Зургаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүрэг

6.1. Ажлын алба мэргэжлийн хороог удирдлага, чиг үүргээр хангаж ажиллана.

6.2. Хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төлөвлөж, жил бүрийн ажлын албаны төсөвт тусгаж, үйл ажиллагааг нь санхүүжүүлнэ.

6.3. Гишүүдэд ажлын оролцоог нь харгалзан улирал бүр урамшуулал олгоно.

6.4. Гишүүдэд олгох урамшуулын хэмжээг ажлын албаны саналыг үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно.

6.5. Хорооны үйл ажиллагааг зохицуулж, үндэсний зөвлөлийн гишүүд ажлын албатай харилцах болон хуралдааны зар түгээх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг Үндэсний зөвлөл, ажлын албанд танилцуулах чиг үүрэг бүхий ажилтныг ажиллуулна.

6.6. Энэ журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын өрөө, техник хэрэгслээр хангах, хуралдааны танхимыг гаргаж өгөх;

6.7. Хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгах.

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.2. Журамд Нийгмийн даатгалын үндэсний тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7.3. Хорооны үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй, чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн гишүүний асуудлыг ажлын албаны саналыг үндэслэн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгон хариуцлага тооцно.

